



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар Б/31

Цэнхэрмандал сум

"Ёс зүйн дэд хороо"-ны гишүүдэд
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.5 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1 дэхь заалт, Монгол улс ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн нэрсийг хавсралтаар баталж, ажлын үр дүн, идэвхи оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг төсвийн хүрэлцээг харгалзан улирал тутам олгосугай.

2. Ёс зүйн хорооны дарга, гишүүдэд олгох урамшууллыг цалин санд багтаан бодож олгохыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА